

## 2020 ОНЫ АЛДАРШУУЛАЛТЫН ТАЙЛАН.

Улаанбаатар хот

2020.12 .22

### Үндэслэл:

#### **Зорилт-1 ЦССҮТ-ийн захиралын 2016 оны А/52 “Алдаршуулах журам”**

2016.01 дүгээр сараас эхлэн жил бүрийн нэгдүгээр сарыг “Донорын баяр”-ын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж байхаар болсонтой холбогдуулан “Хүндэт донор”-уудын дунд 150-аас дээш удаа цусаа бэлэглэсэн доноруудыг “Алтан донор”-оор, 100-аас дээш удаа цусаа бэлэглэсэн доноруудыг “Мөнгөн донор”-оор, 70-аас дээш өгөлттэй доноруудыг “Хүрэл донор”-оор өргөмжлөн алдаршуулан шагнахаар тогтсон. Энэхүү шагналаар Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-өөр болзол хангасан 3 “Хүндэт донор”-ыг тус тус шагнаж урамшуулж байна.

2020 онд нийт-

Хүндэт доноруудыг шагнаж урамшуулсан. Үүнээс

- Алтан донор - 0
- Мөнгөн донор-6
- Хүрэл донор- 12

2016 - 2020 оны хугацаанд алтан донор-7, мөнгөн донор -41, хүрэл донор-114 хүндэт донор медалиа гардан авсан.



#### **Зорилт- 2 “Бахархал-10,20,30,40” тэмдэг, батламжаар шагнах ажлын хүрээнд:**

хагас жилд нийт донорыг урамшуулсан. Үүнээс

10 тэмдэгээр- 20 донор

20 тэмдэгээр- 18 донор

30 тэмдэгээр- 13 донор

40 тэмдэгээр- 9 донор

50 тэмдэгээр – 9 донор нийт 69 донор шагналаа гардан авсан.



### **Зорилт-3 5-аас дээш цусаа өгсөн донорт Захиралын нэрэмжит “Талархал”-аар шагнах:**

2020 оны 1-р улиралд нийт 30 донорыг “Талархал”-аар урамшуулсан.



### **Зорилт-4 Хамтран ажилладаг байгууллагын хүмүүст олгосон шагналын хүрээнд: Нийт 2 байгууллагын 5 хүнийг шагнаж урамшуулсан.**

1. JCI Капитал байгууллагын 2015 оны дэд ерөнхийлөгч Л.Батхуяг МУЗН-ийн “Энэрэл” алтан медаль,
2. JCI Капитал байгууллага Цусны албаны” Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан.
3. Сэтгэлийн 1000 үйлс ТББ-ийн удирдах зөвлөлийн гишүүд болох Б.Баясалмааг МУЗН-ийн “Нигүүлсэл “ Алтан медаль, гишүүд болох М.Мөнхбаяр, Б.Ананд, Г.Очирбат нарыг “Нигүүлсэл “ мөнгөн медалиар тус тус шагнаж урашуулсан.



Цусны албаны “Хүндэт тэмдгээр” МДХ-ны гүйцэтгэх захирал Д.Мандах, М.Гэрэлчимэг, МУЗН-ийн СХД-ийн аргазүйч Ө.Барбаатар нар шагнагдсан.



Цусны донорын үйлсийг дэмжин хамтран ажилладаг байгууллага хамт олныг шагнаж урамшуулав .Үүнд: “Гурван гал” эмнэлгийн хамт олныг “ДОНОР ХАМТ ОЛОН”-оор,

“Жем Интернэшнл” ХХК-ийг “ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛСИЙГ ДЭМЖИГЧ”

МУИС-ийн дэргэдэх "Клуб-25"-ын идэвхтэн залуусыг “ШИЛДЭГ КЛУБ-25”-аар тус тус өргөмжилж, мөнгөн шагнал авсан.



**Зорилт-5: 2019 оны шилдэг доноруудыг Хүмүүнлэгийн одон медиалаар шагнах:**

Ховор бүлгийн донор П.Баасанжаргал Нигүүлсэл мөнгө ,Хөтлөгч Г.Ган-Эрдэнэ “Энэрэл” алт, 2019 оны хамгийн өндөр оноо цуглуулсан Хүндэт донор Г.Хишигжаргал Нигүүлсэл мөнгөн медалиар шагнагдсан.

**Зорилт-6: 2020 оны ЦДДӨ-ийн арга хэмжээний үеэр шагнал авсан тухай :**

Мөнгө, хүрэл доноруудын төлөөлөлөөр ”Мөнгөн донор”-оор С.Отгонбаяр, ”Хүрэл донор”-оор Ц.Өлзийхишиг нарыг тус тус өргөмжлөгдөн шагналаа гардан авсан. Хамгийн залуу “Хүндэт донор”-оор 21 настай Б.Пүрэвнамжил, “Хамгийн олон өгөлттэй донор”-оор жилийн хугацаанд 15 удаа цус,цусны бүрэлдэхүүн хэсгийг бэлэглэсэн Хүндэт донор Н.Мөнхнасан тус тус шалгарлаа.





МУЗН,ЦССҮТ хамтран жил бүр донор элсүүлэгч, сурталчлагч нарыг ажлын үр дүн гүйцэтгэлээр нь дүгнэдэг уламжлалтай. Энэ удаа Баянзүрх дүүргийн Улаан загалмай Тэргүүн байр, Сонгинохайрхан дүүргийн улаан загалмайн хороо дэд, МДХ 3-р байранд шалгарч өргөмжлөл МУЗН-ийн гарын бэлэг тус бүр гардан авсан.

“Донор хамт олон”оор Зэвсэгт хүчний 032-р анги, Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажилтан , албан хаагчид тодорон шагналаа гардан авсан.



Мөн донорын үйлсийг сурталчлагч шилдэг хэвлэл мэдээллийн байгууллагаар Eagle, unep,[mnсайт](http://mnсайт) шалгарсан.

**Зорилт-7: 2020 оны 10 сарын 29 Нийслэл хот байгуулагдсаны 381жилийн ойн баяраар доноруудыг шагнах ажлын хүрээнд :**

100-аас дээш удаа цусаа өгсөн доноруудаас нийт 9 донор нийслэлийн шагналаар шагнагдсан байна.

Нийслэлийн засаг даргын “Жуух бичиг”-ээр 6 донор,Нийслэлийн тэргүүний ажилтан цолоор 3 хүн шагнагдсан.

